



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 34

Мандалговь

“Дуудлагын худалдааг зохион байгуулах журам”-ыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.13 дах заалт, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 зүйлийн 77.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:


1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийн “Дуудлагын худалдааг зохион байгуулах журам”-ыг нэмэлт өөрчлөлт оруулан нэгдүгээр хавсралтаар, “Нээлттэй дуудлагын худалдааны зар мэдээ”-г хоёрдугаар хавсралтаар, “Дуудлагын худалдааны тэмдэглэл”-ийг гуравдугаар хавсралтаар, “Дуудлагын худалдаа зохион байгуулсан тайлан”-г дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх журмыг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг орон нутгийн өмчит байгууллагуудын дарга /захирал/, бүх шатны Засаг дарга нарт, биелэлтийг жил бүр тайлагнаж байхыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (С.Хулан)-д даалгасугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 09 дугаар сарын 19-ны өдрийн 51 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 07 дугаар сарын 08 -ны өдрийн
34 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

“ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ”

Нэг. Нийтлэг үндэслэл

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг баримтлан дуудлагын худалдаагаар худалдахад энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. Дуудлагын худалдааг зарлах, зохион байгуулах

2.1. Аймгийн ИТХ-ын тогтоол хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш хуанлийн 14 хоногийн дотор дуудлага худалдааны талаархи зар мэдээг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас баталсан маягтын дагуу Орон нутгийн өмчийн газар нийтэд зарлан мэдээлнэ.

2.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгө анхны дуудлага худалдаагаар худалдагдаагүй бол дуудлага худалдааг эхний дуудлага худалдаа явуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор тогтоосон доод үнийг өөрчлөлгүйгээр дахин зарлан явуулж, мөн зарагдаагүй тохиолдолд худалдах доод үнийг 30 хүртэл хувиар бууруулан шинэчлэн тогтоож гурав дахь дуудлага худалдааг зарлах, эсхүл өмч эзэмшигч байгууллагын саналыг харгалзан акталж данснаас хасах асуудлыг аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

2.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн дуудлага худалдааг Орон нутгийн өмчийн газрын байранд зохион байгуулна.

2.4 Дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсгийг 5-7 хүний бүрэлдэхүүнтэй, мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулан аймгийн Засаг дарга, эсхүл Орон нутгийн өмчийн газрын даргын шийдвэрээр байгуулна.

2.5 Ажлын хэсэг дуудлага худалдаанд оруулах материалыг урьдчилан хянан үзэж, дүгнэлт гарган Орон нутгийн өмчийн газрын даргад танилцуулсны дараа дуудлага худалдааг зохион байгуулна.

2.6 Дуудлага худалдаа зохион байгуулсан ажлын хэсэг ажлын 3 хоногт багтаан аймгийн Орон нутгийн өмчийн газарт тайлангаа ирүүлнэ.


2.7 Дуудлагын худалдаанаас олсон орлогыг 100,0 хувь орон нутгийн төсвийн хөрөнгө борлуулсны орлогын дансанд төвлөрүүлнэ.

Гурав. Дуудлагын худалдаанд оролцогчдыг бүртгэх;

3.1. Дуудлагын худалдаанд оролцохыг хүсэгчид нь "Дуудлагын худалдаанд оролцох хүсэлт"-ийн маягтыг үнэн зөв, гаргацтай бүрэн гүйцэд бөглөх бөгөөд түүнээс үүсэх хариуцлагыг оролцогч өөрөө хариуцна.

3.2. Дуудлагын худалдаанд оролцохыг хүсэгчид дараахь материалыг бүрдүүлнэ;

Иргэний хувьд:

- 
1. Дуудлагын худалдаанд оролцох хүсэлт гаргах маягт;
 2. Иргэний үнэмлэх, хуулбарын хамт;
 3. Дэнчин тушаасан баримт;
 4. Дуудлагын худалдаанд итгэмжлэгдсэн төлөөлөгч оруулах бол нотариатаар баталгаажуулсан итгэмжлэл, иргэний үнэмлэх.

Хуулийн этгээдийн хувьд:

1. Дуудлагын худалдаанд оролцох хүсэлт гаргах маягт;
2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар (нотариатаар баталгаажуулсан)
3. Дэнчин тушаасан баримт;
4. Дуудлагын худалдаанд итгэмжлэгдсэн төлөөлөгч оруулах шийдвэр, эсхүл нотариатаар баталгаажуулсан итгэмжлэл

Дөрөв. Дэнчин

4.1. Орон нутгийн өмчийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын эд хөрөнгө болон орон нутгийн орлого болж хураагдсан эд хөрөнгийн дуудагдах доод үнийн 10 хувиар, үл хөдлөх хөрөнгийн дуудагдах доод үнийн 30 хувиар тус тус дэнчингийн хэмжээг тогтооно.

4.2. Дэнчинг орон нутгийн төсвийн хөрөнгө борлуулсны орлогын дансанд тушаасан байна.

4.3. "Худалдах, худалдан авах гэрээ"-ний маягтад дуудлагын худалдаанд ялагчийн урьдчилан төлсөн дэнчинг худалдан авсан эд хөрөнгийн үнийн дүнгээс хасч тооцон, тушаах мөнгөний хэмжээ, төлбөр хийх хугацааг тусган өмч эзэмшигч хуулийн этгээдийн төлөөлөгч, ялагчтай гэрээ байгуулна.

4.4. Дуудлагын худалдаанд шалгараагүй оролцогчийн дэнчинг ажлын 3 өдрийн дотор Орон нутгийн өмчийн газар ямар нэгэн шимтгэлгүйгээр буцаан олгоно.

4.5. Дуудлагын худалдааны ялагч, худалдан авсан эд хөрөнгийн төлбөрийг Төрийн сангийн дансанд гэрээнд заасан хугацаанд багтаан тушаах бөгөөд төлөөгүй тохиолдолд дэнчинг орон нутгийн орлого болгож, худалдан авах эрхийг дараах үнийн санал гаргасан оролцогчид санал болгоно.

Тав. Дуудлагын худалдааны үнэ хаялцах хязгаарыг тогтоох

5.1. Дуудлагын худалдаагаар худалдах эд хөрөнгийн худалдаагаар санал болгох доод үнэ 1'000'000 (нэг сая) хүртэл төгрөг бол үнэ хаялцах доод хязгаар 100'000 (нэг зуун мянга) төгрөг, 1'000'001 (нэг сая нэг) төгрөгөөс 5'000'000 (таван сая) хүртэл төгрөг бол үнэ хаялцах доод хязгаар 500'000 (таван зуун мянга) төгрөг, 5'000'001 (таван сая нэг) төгрөгөөс 10'000'000 (арван сая) хүртэл төгрөг бол үнэ хаялцах доод хязгаар 1'000'000 (нэг сая) төгрөг, 10'000'001 (арван сая нэг) төгрөгөөс дээш бол үнэ хаялцах доод хязгаар 2'000'000 (хоёр сая) төгрөг, дээд хязгаар нь 3'000'000 (гурван сая) төгрөг хүртэл байна.

5.2. Дуудлагын худалдаагаар худалдах эд хөрөнгийн худалдах дээд хязгаар нь дэнчингийн хэмжээтэй тэнцүү байна.

Зургаа. Дуудлагаар худалдах хөрөнгийн доод үнийг тогтоох

6.1 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа үндсэн хөрөнгийн худалдах доод үнэ /үнэлгээ/-ийг доорх үзүүлэлтийг үндэслэн өмч эзэмшигч тогтоож, Орон нутгийн өмчийн газар баталгаажуулна.



- А. Үл хөдлөх хөрөнгө
1. Балансын болон үлдэгдэл өртөг
 2. Сүүлийн их засварын капиталжуулсан байдал
 3. Үл хөдлөх хөрөнгө оршин байгаа нутаг дэвсгэрийн газрын сангийн зэрэглэлийн нэгж талбайн суурь үнэлгээ
 4. Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн бодит үнэлгээ
 5. Мэргэжлийн байгууллагын дүгнэлт

Б. Хөдлөх хөрөнгө

1. Гарал үүсэл
2. Ашигласан хугацаа
3. Хөрөнгийн ерөнхий болон техникийн төлөв байдал
4. Балансын болон үлдэгдэл үнэ, ашиглалтын үеийн элэгдэл
5. Ашиглагдах үеийн сүүлийн 3 жилийн сэргээн босголтын зардал
6. Зориулалт
7. Зах зээлийн эрэлт, хэрэгцээ

Долоо. Дуудлагын худалдааг зохион байгуулах ажлын хэсгийн эрх, үүрэг

7.1. Ажлын хэсэг нь дуудлага худалдааг хянагч, дуудлага худалдааны хөтлөгч, тэмдэглэл хөтлөгч гэсэн бүрэлдэхүүнтэй байна.

7.2. Ажлын хэсэг дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

1. Дуудлагын худалдаанд оролцогчдыг бүртгэж, баримт бичгийг шалгасны эцэст оролцогч бүрт дугаар бүхий пайз олгоно.

2. Дуудлагын худалдаанд 2 оролцогч оролцож байгаа тохиолдолд оролцогч бүр анхны үнийг заавал дуудна. Анхны үнэ дуудаагүй татгалзсан тохиолдолд дуудлагын худалдааг яваагүйд тооцож, энэ тухай тэмдэглэлд тусган дэнчинг буцаан олгохгүй, орон нутгийн төсвийн орлого болгоно.

3. Дуудлагын худалдаанд нэг ч этгээд ирээгүй, эсхүл хоёроос доош этгээд ирсэн, худалдах доод үнээс дээш үнийн санал гараагүй бол дуудлагын худалдааг явагдаагүйд тооцон энэ тухай тэмдэглэл үйлдэнэ.

7.3. Дуудлага худалдааны хянагч дараахь эрх, үүрэгтэй

1. Дуудлагын худалдааг зохион байгуулж явуулахтай холбогдсон хууль тогтоомж, журмын заалт, эд хөрөнгө худалдах тухай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрийг тус тус танилцуулж, оролцогчдод дуудлагын худалдаа эхэлснийг мэдэгдэн, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн дагуу эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

2. Дуудлагын худалдаанд оролцогчдоос холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллахыг шаардах, дуудлага худалдааны явцад оролцогчдоос хууль журмыг зөрчиж, үнэ хаялцуулах өрсөлдөөнийг хязгаарласан, үнэгүйдүүлэх үйлдэл илт илэрч байгаа тохиолдолд дуудлагын худалдааг зогсоож, хүчингүй болгон, энэ тухай дуудлагын худалдааны явцын тэмдэглэлд тодорхой тусгуулна.

3. Дуудлага худалдааны хянагч нь дуудлагын худалдааны тэмдэглэлийг хянан үзсэний дараа тэмдэглэлд гарын үсэг зурна.

7.4. Дуудлагын худалдааны хөтлөгч нь дараахь эрх, үүрэгтэй

1. үнэ хаялцах доод болон дээд хязгаарыг зарлана.

2. дуудлагын худалдаа эхэлснийг зарлан мэдээлсний дараа үнэ хаялцах ажиллагааг тусгай дохиогоор эхлэн дуудлагын худалдаанд оролцогчдын үнийн саналыг пайз өргөсөн дарааллаар дуудна.

3. дуудлагын худалдаанд оролцогчийн үнийн саналыг гурван удаа давтаж хэлнэ.

4. хамгийн сүүлд гарсан үнийн саналыг гурван удаа давтан "буулаа" нэг, хоёр, гурав гэж тоолсны дараа шинээр үнийн санал гараагүй бол тусгай дохиогоор дуусгавар болгон ялагчийг зарлан мэдээлнэ.

5. Дуудлага худалдааны хөтлөгч дуудлагын худалдааны тэмдэглэлийг хянан үзсэний дараа тэмдэглэлд гарын үсэг зурна.

6. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн дагуу үүрэг хүлээнэ.

7.5 Дуудлагын худалдааны тэмдэглэл хөтлөгч нь дараахь эрх, үүрэгтэй

1. Дуудлагын худалдаанд оролцогчдыг бүртгэнэ.

2. Дуудлагын худалдааны явцын тэмдэглэлийг үнэн зөв, бүрэн хөтлөнө.

3. Дуудлагын худалдааны үнэ хаялцах доод болон дээд хязгаарыг дуудлагын худалдааны тэмдэглэлд тусгана.

4. Дуудлагын худалдаанд оролцогчдын үнийн саналыг пайз өргөсөн дарааллаар явцын тэмдэглэлд бичнэ.

5. дуудлагын худалдаанд 2-оос доош этгээд оролцсон, доод үнээс дээш үнийн санал ирээгүй бол дуудлага худалдааг явагдаагүйд тооцон хааж энэ тухай тэмдэглэл үйлдэнэ.

6. Дуудлагын худалдааны явцын тэмдэглэлд дуудлага худалдааны хянагч, дуудлага худалдааны хөтлөгч, дуудлага худалдааны тэмдэглэл хөтлөгч нар гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж баталгаажина.

Найм. Дуудлага худалдааг дуусгавар болгох


8.1.1 Дуудлагын худалдааг үнэ хаялцуулж дууссаны дараа дохио өгч хааснаар дуусгавар болсонд тооцно.

8.1.2 Дуудлагын худалдаанд хамгийн өндөр үнэ өгсөн ялагчтай "Худалдах, худалдан авах гэрээ"-г байгуулна.

8.1.3 Дуудлагын худалдаанд ялагч худалдан авсан хөрөнгийн үнийг гэрээ байгуулснаас хойш 14 хоногийн дотор холбогдох дансанд тушаах бөгөөд баримтыг үндэслэн дуудлагын худалдаа зохион байгуулсан ажлын хэсгийн шийдвэрийн дагуу хөрөнгө эзэмшигч байгууллагын "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийн удирдлага дор хөрөнгийг акт үйлдэн худалдан авагчид хүлээлгэн өгнө.

8.1.4 Хөрөнгө худалдан авагч заасан хугацаанд хөрөнгийн үнийг төлөөгүй нөхцөлд түүний төлсөн дэнчинг орон нутгийн төсвийн орлого болгож, худалдан авах эрх дараагийн үнийг санал болгосон оролцогчид шилжих бөгөөд уг оролцогч хөрөнгийн үнийг 14 хоногийн дотор холбогдох дансанд төлнө.

8.1.5 Дуудлагын худалдаагаар худалдан авсан хөрөнгийн өмчлөх эрх нь гэрээний дагуу үнийг хугацаанд бүрэн төлсний дараа үүснэ.



Ес. Дуудлагын худалдааг дахин явуулах

9.1. “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 44 дүгээр зүйлд заасны дагуу дуудлага худалдааг дахин явуулна.

9.2. Дуудлагын худалдааг дахин явуулах шийдвэрийг Орон нутгийн өмчийн газрын дарга гаргах ба зарыг уг худалдааг явуулахаас 14-өөс доошгүй хоногийн өмнө нийтэд мэдээлнэ.

9.3. Дуудлагын худалдааг дахин явуулахдаа “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль” болон энэхүү журмыг баримтална.

9.4. Нийтийн дуудлагын худалдаагаар худалдаалах эд хөрөнгийн доод үнийг өөрчлөхгүйгээр дахин дуудлагын худалдаа явуулах болон дуудлагын худалдаагаар зарагдсан эд хөрөнгийн төлбөр, тооцоо бүрэн хийгдэж орон нутгийн төсвийн дансанд төлбөр нь бүрэн орж ирсэн нөхцөлд өмчлөгчийн эрх олгох тухай асуудлыг Орон нутгийн өмчийн газар шийдвэрлэнэ.

Арав. Дуудлагын худалдаа зохион байгуулахтай холбоотой
гарах зардал

10.1 Дуудлагын худалдаагаар авсан хөрөнгийг худалдан авагчид хүлээлгэн өгөхөөс өмнөх хугацааны тухайн хөрөнгөтэй холбоотой татвар, төлбөр, хураамж, даатгал зэрэг төлөгдөөгүй зардлыг хөрөнгө эзэмшигч байгууллага хариуцан барагдуулна.

10.2 Эд хөрөнгийг өмчлөх эрх шилжүүлэхтэй холбоотой гарах үйлчилгээний хураамж болон бусад зардлыг худалдан авагч өөрөө хариуцна.

10.3 Дуудлагын худалдааны зар мэдээг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлэхтэй холбоотой гарах зардлыг хөрөнгө худалдсаны орлогоос баримтыг үндэслэн барагдуулна.

Арван нэг. Дуудлагын худалдааны явцад үүссэн маргааныг хянан шийдвэрлэх,
хариуцлага

11.1 Дуудлагын худалдааны явцад үүссэн маргааныг аймгийн Орон нутгийн өмчийн газар шийдвэрлэнэ. Орон нутгийн өмчийн газрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол шүүхэд гомдол гаргаж болно.

11.2 Энэ журмыг зөрчиж орон нутгийн өмчийн хөрөнгийг худалдсан нь нотлох баримтаар тогтоогдсон бол гэм буруутай этгээдээр уг хохирлыг нөхөн төлүүлж, хуулийн хариуцлага хүлээлгэнэ.

11.3 Дуудлага худалдааг санаатайгаар будилаантуулсан нь нотлох баримтаар тогтоогдсон бол дахин дуудлага худалдаанд оролцох эрхийг хасна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн
34 дүгээр тогтоолын хоёдугаар хавсралт

ДУУДЛАГЫН ХУДАЛДААНЫ ЗАР МЭДЭЭ

Дундговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 202... оны ... дүгээр тогтоолын дагуу.....(худалдах хөрөнгийн нэр) хөрөнгийг нээлттэй/хаалттай дуудлага худалдаагаар худалдана.

1. Дуудлагын худалдааны ерөнхий мэдээлэл


1	Дуудлагын худалдааны хэлбэр	Нээлттэй/хаалттай
2	Гэрээний зүйл	Худалдах хөрөнгийн гарал үүсэл, ашигласан хугацаа, марк, техникийн үзүүлэлт, улсын бүртгэлийн дугаар, төлөв байдал, товч танилцуулга
3	Дуудлагын худалдаа болох хугацаа	20....оныдугаар сарын.....-ны өдрийнцагт
4	Дуудлагын худалдаа болох газар
5	Худалдах доод үнэ	Дуудлагаар худалдах хөрөнгийн нэр, худалдах доод үнэ(тоогоор).....(үсгээр) төгрөг
6	Дуудлагын худалдаанд тавин дэнчингийн хэмжээ	Худалдах доод үнийнхувь буюу.....(тоогоор).....(үсгээр) төгрөг
7	Ялсан этгээдийг тогтоох журам	Үнэ хаялцсан ялагч нь хамгийн өндөр үнэ санал болгосон этгээд байна.
8	Худалдах, худалдан авах гэрээний ерөнхий нөхцөл	Гэрээг ажлын 3 хоногийн дотор байгуулна. Худалдан авагч нь дуудлага худалдаагаар худалдан авсан эд хөрөнгийн үнийг 14 хоногийн дотор төлнө.
9	Дэнчинг байршуулах данс	Дансны нэр: Дансны дугаар:

Дуудлагын худалдаанд хүсэлт ирүүлэх

Дуудлагын худалдаанд оролцох хүсэлтийн маягт 20... оны ... дугаар сарын.....-ны өдрийн ... цаг хүртэлхуулийн этгээдийн ерөөнд хүлээн авна. Хугацаа хоцорсон хүсэлтийг хүлээн авах боломжгүйг анхаарна уу. Дуудлагын худалдаанд оролцох хүсэлт нь зөв, цэвэр бөглөсөн худалдаанд оролцох хүсэлтийн маягт, дэнчин төлснийг нотлох баримт, иргэний үнэмлэхийн хуулбар (хуулийн этгээдийн хувьд улсын бүртгэлийн гэрчилгээ)-ийн хуулбар зэрэг баримтаас бүрдэнэ.

Худалдах хөрөнгийн талаарх мэдээлэл авах

Дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийг үзэж танилцсан байх шаардлагатай бөгөөд дуудлагын худалдааны журам, бүртгэх хугацаа, хөрөнгийн талаарх мэдээллийг Орон нутгийн өмчийн газрын утсаар болон цахим хуудаснаас авч болно.



ДУУДЛАГЫН ХУДАЛДААНД ОРОЛЦОХ ХҮСЭЛТИЙН МАЯГТ

1. Дуудлагын худалдаагаар худалдах эд хөрөнгийн эзэмшигч.....
.....(хуулийн этгээдийн нэр)
.....
.....
.....(хөрөнгийн нэр)
2. Оролцогчийн эцгийн нэр, нэр:.....
3. Оролцогчийн регистрийн дугаар:.....
4. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эцгийн нэр, нэр.....
5. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн регистрийн дугаар.....
6. Дэнчингийн хэмжээ.....(тоогоор)
.....(үсгээр)
7. Дэнчинг тушаасан: 20....оны....сар....өдөр,цаг
8. Оролцогчийн оршин суугаа хаяг.....
.....
9. Харилцах утас:.....
10. Бөглөсөн: 20....оны....сар....өдөр,цаг
11. Дуудлагын худалдааны нөхцөл болон.....
.....
.....(эд хөрөнгийн нэр) эд хөрөнгөтэй
танилцсан.....Гарын үсэг

- Дуудлагын худалдаанд оролцох бүрт энэ хүснэгтийг бөглөж, дэнчинг төлсөн баримтын 1 хувь, оролцогчийн иргэний үнэмлэхийн хуулбарыг хавсаргаж, дугуйлж бүртгүүлнэ.
- Хүсэлтэд бичигдсэн мэдээллийн үнэн зөв байдлыг оролцогч бүрэн хариуцах ба алдаатай, буруу бөглөсөн бол дуудлагын худалдаанд оролцох боломжгүйг анхаарна уу.



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн
34 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт

ДУУДЛАГЫН ХУДАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

20... оны ... сарын өдөр

1. Өмчлөгч байгууллагын нэр.....
 2. Дуудлага худалдаагаар худалдах эд хөрөнгийн нэр, марк, дугаар, тоо хэмжээ:
.....
.....
.....
 3. Дуудлага худалдааны тухай зарласан сонины нэр, дугаар, он сар өдөр:
.....№....., 20.... оны....сар.....өдөр
 4. Дуудлага худалдааны доод үнэ
 5. Дэнчингийн хэмжээ төгрөг/үсгээр/ /..... / төгрөг.
 6. Оролцогчдын нэр
1.....
2.....
3.....
4.....
 7. Ажиглагчдын нэрс
1.
2.
7. Нэмэлт тэмдэглэл

Дуудлага худалдааг зохион байгуулж явуулсан:

1. Хөтлөгч:
2. Тэмдэглэл хөтлөгч:
Хөтлөгч дуудлага худалдааны журмыг танилцуулж, дуудлага худалдаа эхэлснийг зарлав.Өсгөн нэмэгдүүлэх үнийн доод хязгаарыг
.....
/...../ төгрөгөөр, дээд хязгаарыг
..... /...../ төгрөгөөр тус тус
байхаар тохиров

Дуудлага худалдаа дараах байдалтай явагдав.



№	Пайзны дугаар	Үнийн санал

№	Пайзны дугаар	Үнийн санал

№	Пайзны дугаар	Үнийн санал

Дуудлага худалдааны эцсийн үнэ:төгрөг,
/үсгээр.....

/

Удаах оролцогчийн эцсийн үнийн санал:.....төгрөг,
/үсгээр.....

/

Дуудлага худалдаанд ялагчийн овог нэр ..
.....

Оршин суугаа хаяг, харилцах
утас.....
.....

Удаах оролцогчийн овог нэр
.....

Оршин суугаа хаяг, харилцах
утас.....
.....

Дуудлага худалдааны тэмдэглэлтэй танилцсан:

Дуудлага худалдааны хөтлөгч хөтлөгч.

...../...../

Дуудлага худалдааны тэмдэглэл хөтлөгч...../

...../

Дуудлага худалдааны ажиглагч:...../

...../

Дуудлага худалдааны ажиглагч:...../

...../

Дуудлага худалдаанд оролцогч:

/...../

Дуудлага худалдаанд оролцогч:

/...../





Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн
34 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралт

ДУУДЛАГЫН ХУДАЛДАА ЗОХИОН БАЙГУУЛСАН ТАЙЛАН
Хуулийн этгээдийн нэр.....
.....

Тайлагнах үзүүлэлт	Хэрэгжсэн байдал
Дуудлагын худалдаа явуулах шийдвэр	
Худалдсан хөрөнгийн мэдээлэл	
Ажлын хэсэг (комисс)	
Дуудлагын худалдааны зар мэдээ	
Дуудлагын худалдааны тэмдэглэл, Худалдах худалдан авах гэрээ	
Дуудлагын худалдаа болсон хугацаа	
Дуудлагын худалдаа болсон газар	
Худалдах доод үнэ	
Дуудлагын худалдаанд тавих дэнчингийн хэмжээ	
Худалдсан үнэ	
Дуудлагын худалдааны ялагч	
Ду.Хөрөнгө борлуулсны орлогын дансанд төвлөрүүлсэн дүн	

Дуудлагын худалдааг зохион байгуулсан ажлын хэсэг:
Ахлагч...../...../
Гишүүд...../...../
...../...../
...../.....